

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул дүүргийн Хан Эко тээвэр ОНӨААТҮГ-ийн  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/047/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г. Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a></p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 9909-9119 Цахим хаяг: <a href="mailto:gerelthuhaudit@gmail.com">gerelthuhaudit@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	<b>Error! Bookmark not defined.</b>
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1 Ерөнхий зүйл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2 Материаллаг байдал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026-05-13

№

891

танай

-ны №

-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Хан Эко тээвэр ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны нийт орлого, нийт зардлыг 7,703.2 сая төгрөг байхаар баталснаас гүйцэтгэлээр 8,581.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 6,913.6 сая төгрөгийг зарцуулан 1,668.2 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд Хан-Уул дүүргийн засаг даргын 7 удаагийн захирамжаар нийт 573.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

C:\User\nerangui\Desktop\Emer... 1426050909

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	58,791,953.06	1,668,256,171.94
Татвар, НДШ – ийн авлага	160,796.00	-
Бусад авлага	1,374,000.00	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	32,600,000.00	-
Бараа материал	205,051,638.50	215,800,578.82
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>297,978,387.56</b>	<b>1,884,056,750.76</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	2,790,739,109.81	2,503,907,131.94
Биет бус хөрөнгө	13,651,556.82	10,558,741.54
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,804,390,666.63</b>	<b>2,514,465,873.48</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,102,369,054.19</b>	<b>4,398,522,624.24</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Цалингийн өглөг	1,669,193.00	-
Татварын өр	9,644,828.84	166,821,707.12
Урьдчилж орсон орлого	2,540,336,912.24	2,199,387,432.94
Бусад богино хугацаат өр төлбөр	19,800,000.00	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,571,450,934.08</b>	<b>2,366,209,140.06</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,571,450,934.08</b>	<b>2,366,209,140.06</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч:-терийн	-	-
Хуримтлагдсан ашиг	444,114,660.56	530,918,120.11
Тайлант үеийн үр дүн	86,803,459.55	1,501,395,364.07
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>530,918,120.11</b>	<b>2,032,313,484.18</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,102,369,054.19</b>	<b>4,398,522,624.24</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>4,672,074,077.40</b>	<b>8,031,983,482.30</b>
1.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>4,672,074,077.40</b>	<b>8,031,983,482.30</b>

6	Бусад орлого	261,241,394.99	549,891,382.43
8	Ерөнхий ба удирдлагын зардал	4,836,867,184.00	6,913,657,793.54
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>96,448,288.39</b>	<b>1,668,217,071.19</b>
19	Орлогын татварын зардал	9,644,828.84	166,821,707.12
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>86,803,459.55</b>	<b>1,501,395,364.07</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>86,803,459.55</b>	<b>1,501,395,364.07</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>86,803,459.55</b>	<b>1,501,395,364.07</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,676,295,263.40</b>	<b>8,034,417,677.63</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,672,074,077.40	8,031,983,482.30
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,221,186.00	2,434,195.33
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,602,713,384.45</b>	<b>6,377,526,858.75</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,624,363,198.92	4,143,401,358.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	348,514,512.07	540,008,430.07
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	355,179,144.00	459,516,673.98
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	114,180,000.00	131,703,400.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	677,784,574.00	528,828,896.37
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,608,729.00	5,135,312.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага	481,083,226.46	568,932,787.90
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>73,581,878.95</b>	<b>1,656,890,818.88</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>62,530,295.72</b>	<b>47,426,600.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	62,530,295.72	47,426,600.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(62,530,295.72)</b>	<b>(47,426,600.00)</b>
4	<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>11,051,583.23</b>	<b>1,609,464,218.88</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>47,740,369.83</b>	<b>58,791,953.06</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>58,791,953.06</b>	<b>1,668,256,171.94</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл			838,832,647.61	838,832,647.61
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(394,717,987.05)	(394,717,987.05)
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>			<b>444,114,660.56</b>	<b>444,114,660.56</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			86,803,459.55	<b>86,803,459.55</b>
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	530,918,120.11	530,918,120.11
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.00
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>530,918,120.11</b>	<b>530,918,120.11</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,501,395,364.07	<b>1,501,395,364.07</b>
17	2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	2,032,313,484.18	2,032,313,484.18

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Биелэлт хувь	Зөрүү
<b>1. Нийт орлого</b>		<b>7,703,163,381.00</b>	<b>8,034,417,677.63</b>	<b>104.30%</b>	<b>(331,254,296.63)</b>
1.1	Сангийн менежментийн үйлчлэгээний орлого	7,703,163,381.00	8,031,983,482.30	104.27%	(328,820,101.30)
<b>2. Нийт зардал</b>		<b>7,703,163,381.00</b>	<b>6,424,953,458.75</b>	<b>83.41%</b>	<b>1,278,209,922.25</b>
2.1	Цалин, урамшуулал, нэмэгдэл, хоол унааны зардал	5,093,184,000.00	4,143,401,358.43	81.35%	949,782,641.57
2.2	Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	706,539,381.00	540,008,430.07	76.43%	166,530,950.93
2.3	Түрээсийн зардал	294,960,000.00	191,400,000.00	64.89%	103,560,000.00
2.4	Байр ашиглалтын зардал	300,000,000.00	131,703,400.00	43.90%	168,296,600.00
2.5	Урсгал засварын зардал	216,000,000.00	152,333,610.00	70.52%	63,666,390.00
2.7	Интернэт, утасны зардал	2,880,000.00	2,564,289.00	89.04%	315,711.00
2.8	Сургалтын зардал	24,000,000.00	4,188,150.00	17.45%	19,811,850.00
2.9	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	165,671,784.98		(165,671,784.98)
2.14	Төлбөр, хураамжийн зардал	234,000,000.00	365,915,660.90	156.37%	(131,915,660.90)
2.15	Бичиг хэрэглэл	12,000,000.00	6,950,959.00	57.92%	5,049,041.00
2.16	Хангамжийн зардал	94,000,000.00	73,309,020.00		20,690,980.00

2.18	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл	96,000,000.00	213,584,910.00	222.48%	(117,584,910.00)
2.19	Компьютер, тоног төхөөрөмж, хэрэгсэл	38,000,000.00	35,861,600.00	94.37%	2,138,400.00
2.2	Тавилга, эд хогшил	12,000,000.00	11,565,000.00	96.38%	435,000.00
2.25	Тээврийн зардал	519,600,000.00	376,495,286.37	72.46%	143,104,713.63
2.28	Үйл ажиллагааны бусад	60,000,000.00	10,000,000.00	16.67%	50,000,000.00
<b>3. Цэвэр ашиг, алдагдал</b>		<b>0.00</b>	<b>1,609,464,218.88</b>		<b>(1,609,464,218.88)</b>

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,461.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийт залруулагдаагүй 22,461.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 85,818.7 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Автомашин засварлахад авсан 10,588.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл техникийн акт хангалтгүй уг эвдрэл ямар шалтгаанаар үүссэн, норм норматив хангаагүй шалтгаан зэрэг тодорхойлоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлийг ханган ажиллах;

#### 2. Эд хариуцагчтай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 2/-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар" гэсэн заалттай нийцээгүй байна санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийн хөдлөл бүрд эд хариуцагчийн картад баяжилт хийж байх ;

### 3. Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой асуудал

**Илрүүлэлт-3:** Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгахад тайлант онд ямар нэгэн ажил гүйлгээ, хөдөлгөөн хийгдээгүй 19 нэр төрлийн 256 тоо хэмжээ бүхий 11,873.5 мянган төгрөгийн бараа материал байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн хуулийг хангаж ажиллах;

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Автомашин засварлахад авсан сэлбэг хэрэгсэл техникийн акт хангалтгүй уг эвдрэл ямар шалтгаанаар үүссэн, норм норматив хангаагүй шалтгаан зэрэг тодорхойлоогүй байна.	1	10,588.0					1	10,588.0
Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй байна.	1	0.00					1	0.00
Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгахад тайлант онд ямар нэгэн ажил гүйлгээ, хөдөлгөөн хийгдээгүй 19 нэр төрлийн 256 ширхэг тоо хэмжээ бүхий 11,873,546.00 төгрөгийн бараа материал байна.	1	11,873.54					1	11,873.54
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>22,461.54</b>					<b>3</b>	<b>22,461.54</b>

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө бэлтгэх шийдвэр худалдан авч хөрөнгө бэлтгэх ажлыг нягтлан бодогчид даалгаж, уг худалдан авалтад хяналт тавихыг гүйцэтгэх захиралд даалгасан байна	1	0.00					1	0.00
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.00</b>					<b>1</b>	<b>0.00</b>

